


“Монлогистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн  
Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 сарын 07-ны өдрийн  
№24/ТУЗ/05 тоот тогтоолын  
№6 дүгээр хавсралтаар батлав.



## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Баримт бичгийн дугаар  
Т1-ТУЗ-04

**АГУУЛГА**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	1
ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙГ ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ.....	1
ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ШИЙДВЭР .....	1
ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, МЭДЭЭЛЛЭХ, ТАЙЛАГНАХ.....	2
ТАВ. БУСАД ЗҮЙЛ .....	2

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Ногдол ашгийн бодлого” /цаашид “Бодлого” гэх/-ын зорилго нь Монложистикс Холдинг ХК (цаашид “Компани” гэх) -ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон хуваарилах нөхцөлийг тодорхойлох, түүнийг хуваарилах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээллэх, ногдол ашиг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү Бодлогыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн засаглалын кодекс болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм, журамд нийцүүлэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

### ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙГ ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ

- 2.1. Энэхүү Бодлого нь компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байх ба Компанийн хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд хуваарилах зарчмыг баримтална.
- 2.2. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, нөхцөлийг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 2.3. Бодлогын 2.2-т заасны дагуу тогтоох ногдол ашгийн хэмжээ нь татварын дараах цэвэр ашгийн 20-50 хувь байна.
- 2.4. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- 2.5. Компани нь 2.3-т дурдсан ногдол ашгийг хуваарилахдаа дор дурдсан нөхцөлийг харгалзан үзнэ. Үүнд:
  - 2.5.1. Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх
  - 2.5.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэргийн нийлбэрээс их байх;
  - 2.5.3. Компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;
- 2.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах ба Компани эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.
- 2.7. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 2.8. Ногдол ашгийг эд хөрөнгийн болон үнэт цаасны хэлбэрээр олгох тохиолдолд түүний үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмыг баримтлан тодорхойлно.

### ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ШИЙДВЭР

- 3.1. Компанийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:
  - 3.2.1. Хувьцааны төрөл, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
  - 3.2.2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт болон ногдол ашиг

- гаргах бүртгэлийн өдөр;
- 3.2.3. Ногдол ашиг төлөх өдөр буюу олгож эхлэх, дуусах хугацаа;
- 3.2.4. Ногдол ашгийг олгох хэлбэр;
- 3.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ногдол ашиг хуваарилах талаар ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдэгдэх үүрэгтэй.
- 3.4. Компани нь тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа үндэслэл шалтгаан, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

#### **ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, МЭДЭЭЛЛЭХ, ТАЙЛАГНАХ**

- 4.1. Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, бодлого нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- 4.2. Ногдол ашгийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан, ногдол ашиг хуваарилах гэрээний үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлнэ.
- 4.3. Ногдол ашиг олгох өдрийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 60-аас илүүгүй хоног байхаар тооцож, ногдол ашиг тараах хугацааг тогтоохийг эрмэлзэнэ.
- 4.4. Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээ хүргэх журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.
- 4.5. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25 хувиас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш 15 өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэх ба мэдэгдэх ажлыг Компанийн гүйцэтгэх захирал хариуцан, хийж гүйцэтгэнэ.
- 4.6. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, тухай бүр Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэнэ.

#### **ТАВ. БУСАД ЗҮЙЛ**

- 5.1. Компани нь ногдол ашгаа ТУЗ-ийн шийдвэрт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба үүнээс үүдэлтэй компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх удирдлага хариуцна.
- 5.2. Хувьцаа эзэмшигч ТУЗ-өөс шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх үндэслэл болохгүй.
- 5.3. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

-----oOo-----